



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 01 өдөр

Дугаар А/483

Булган сум


Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2024 оны “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 02 дугаар тогтоол, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX хуралдааны “Булган аймгийн 2024 оны төсөв батлах тухай” XIX/08 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай 2020 оны II/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Алтаргана 2024” олон улсын XV их наадмын хүндэт зочид төлөөлөгчдийг байрлуулах зардал 62,400,000 (жаран хоёр сая дөрвөн зуун мянга) төгрөгийг хавсралтаар баталж, хууль, дүрэм журмын дагуу гэрээ байгуулан удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Тамгын газрын дарга (Д.Алтаншагай) -д даалгасугай.

2. Дээрхи зардлыг Булган аймаг, Уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2024 онд хамтран ажиллах төлөвлөгөөнд тусгагдсан “Байгаль орчныг хамгаалах зорилгоор байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулах арга хэмжээ”-ний зардлаас санхүүжүүлэхийг Тамгын газрын дарга (Д.Алтаншагай) -д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



БАРИУН-ЭРДЭНЭ

6324010646

07 дүгээр сарын 07 -ны өдрийн 17.483 дугаар захирамжийн хавсралт



“Алтаргана 2024” олон улсын XV наадамд хүрэлцэн ирэх хүндэт зочдыг байрлуулах ажлын төсөв

№	Байрлах газар	Байрлах хүний тоо	Байрлах хоног	Нэгжийн үнэ /төгрөгөөр/	Дүн /мян.төг/
1	“Хангай дисковери” амралтын газар	104	3	155,000	48,360,000
2	Өглөөний цай	104	3	20,000	6,240,000
3	Оройн хоол	104	3	25,000	7,800,000
					62,400,000